

# АРХИВЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ МОНГОЛ-ОРОСЫН ХАМТАРСАН КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙД

Т.САЙНЖАРГАЛ

*Монгол Улсын Үндэсний төв архивын захирал*

## Хамтарсан комиссын түүхээс

Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Архивын салбарт хамтран ажиллах тухай” Хэлэлцээр 1992 оны 3 дугаар сарын 7-ны өдөр байгуулагджээ.<sup>1</sup>

Хэлэлцээрийн зорилго, заалтын хүрээнд 1992 оны 10 дугаар сард Москва хотноо анх удаа хоёр орны архивын байгууллагын төлөөлөгчдийн ажлын уулзалт хийж, архивын салбарт хамтран ажиллах Монгол, Оросын комиссыг албан ёсоор байгуулж, Дүрмийг нь баталсан байдаг.<sup>2</sup>

Тус Хамтарсан комиссын бүрэлдэхүүний хувьд Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын тогтоолоор баталдаг бөгөөд Архивын салбарт хамтран ажиллах Монголын талын анхны бүрэлдэхүүнийг Монгол Улсын Засгийн Газрын 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 62 тоот захирамжаар баталж, ихэнх тохиолдолд Хууль зүйн дэд сайд ахалж ажиллаж байсан бол Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 26-ний өдрийн 23 тоот тогтоолоор бүрэлдэхүүнийг шинэчилж, Архивын ерөнхий газрын дарга ахалж байхаар тогтоосон.

Оросын талын даргаар нь ОХУ-ын Холбооны архивын агентлагийн (Росархив) орлогч дарга ажилладаг бөгөөд Оросын төрийн төв архивууд, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцдог.

Хамтарсан комисс нь өнгөрсөн хугацаанд Монгол, Оросын төрийн архивуудад хадгалагдаж байгаа, урьд өмнө нь далд, хаалттай байсан түүхэн чухал баримт бичгүүдийг судалж, сурвалжлах, хуулбараар солилцох, түүхийн тодорхой сэдвээр хамтарсан баримт бичгийн эмхэтгэл бэлтгэж, хэвлүүлэх, түүхт ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан архивын баримт бичиг, гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж олон нийтэд таниулах, хоёр улсын архивын ажлын туршлага солилцох, ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх зэрэг чиглэлээр тодорхой бодит ажлуудыг амжилттай зохион байгуулж ирсэн.

Үүний нэг тод илрэл 2014 оны 9 дүгээр сард Халх голын ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн

<sup>1</sup> Монгол Улсын Үндэсний төв архив, Х-445, Д-4, ХН-4, хуудас-1

<sup>2</sup> Мөн тэнд

айлчлалын албан ёсны арга хэмжээний хүрээнд Хамтарсан комиссын шугамаар бэлтгэж, хэвлүүлсэн “Халх голын орчим дахь зэвсэгт мөргөлдөөн (1939 оны тав-есдүгээр сар)” эмхэтгэлийн танилцуулах ёслолд ОХУ-ын Холбооны архивын агентлагийн дарга А.Н.Артизов нарын төлөөлөгчид ирж оролцсон явдал юм.

2017 онд Комиссын түүхт 25 жилийн ойг тохиолдуулан хоёр орны архивын байгууллагын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, Монгол төрийн ХХ зууны түүх, ой санамжийг бүрдүүлэх, судалж, ашиглах үйл хэрэгт оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ОХУ-ын төрийн архивын хэсэг ажилтныг Монгол Улсын төрийн одон, медалиар шагнасан нь Архивын салбарт хамтран ажиллах Монгол-Оросын комиссын үйл ажиллагааг Монголын төр өндрөөр үнэлж байгаа нэг жишээ юм.

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монголын Улсын Төрийн дээд шагнал хүртсэн ОХУ-ын архивын ажилтнууд*

д/д	Овог, нэр	Шагналын төрөл	Шагналын зарлигийн огноо, дугаар
1	Кудрявцев Иван Иванович	“Найрамдал” медаль	2001.8.6, №30
2	Козлов Владимир Петрович	“Найрамдал” медаль	2006.10.26, №309
3	Артизов Андрей Николаевич	“Алтан гадас” одон	2017.11.28, №67
4	Тарасов Владимир Петрович	“Найрамдал” медаль	2017.11.28, №67
5	Коротаев Владимир Иванович	“Найрамдал” медаль	2017.11.28, №67
6	Курапова Елена Рудольфовна	“Найрамдал” медаль	2017.11.28, №67

**Хамтарсан комиссын хуралдаанууд**

Комиссын хуралдааныг Дүрмийн дагуу жил бүр 2 тал өөрийн оронд ээлжлэн зохион байгуулдаг уламжлал тогтсон бөгөөд өнгөрсөн 29 жилийн хугацаанд 24 хуралдаан болсны 13 нь ОХУ-д, 11 нь Монгол Улсад болсон.

Комиссын хуралдаанаар хоёр хуралдааны хооронд Комиссын шугамаар хийсэн болон хийгдэж буй ажил төрлийн явц, биелэлтийг дүгнэн хэлэлцэж, дараагийн хуралдаан хүртэл болон ойрын хугацаанд хамтран хийх ажил, арга хэмжээний талаар тодорхой шийдвэр гаргаж, протокол үйлдэж, ажлын төлөвлөгөө, графикийг баталж ирсэн. Мөн хуралдааны үеэр олон нийтэд зориулж хоёр улсын харилцаанд холбогдох түүхийн чухал сэдэв буюу түүхт ойд зориулсан хамтарсан архивын баримт бичгийн үзэсгэлэн нээх, хамтарсан баримт бичгийн эмхэтгэлийг танилцуулах ёслол, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, архив, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарч архив судлалын онол, практикийн асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт зохион байгуулах, архивын ажлын туршлага солилцох зэрэг ажил хэргийн чанартай олон тооны арга хэмжээг хамтран зохион байгуулдаг.

*Хамтарсан комиссын хуралдаанууд (1992-2019 он)*

I	1992.10.12-15	МОСКВА
II	1993.9.7-9	УЛААНБААТАР
III	1994.11.21-23	МОСКВА
IV	1995.10.17-23	УЛААНБААТАР
V	1996.6.24-27	МОСКВА
VI	1998.4.6-9	МОСКВА
VII	1999.9.15-15	УЛААНБААТАР
VIII	1999.8.	ЭРХҮҮ /ИРКУТСК/
IX	2001.8.7-13	ЭРДЭНЭТ
X	2002.6.10-12	САНКТ-ПЕТЕРБУРГ
XI	2003.9.17-20	САЙНШАНД
XII	2004.9.26-30	ИРКУТСК.пос.Усть-Ордынск
XIII	2005.6.27-29	УЛААНБААТАР
XIV	2006.10.30	ЕКАТЕРИНБУРГ
XV	2007.10.2-4	УЛААНБААТАР
XVI	2008.6.2-3	МОСКВА
XVII	2009.8.27	УЛААНБААТАР
XVIII	2010.6.28	УЛААН-ҮДЭ
XIX	2011.10.3-4	УЛААНБААТАР
XX	2012.8.6	МОСКВА
XXI	2015.4.22-24	УЛААНБААТАР
XXII	2016.6.20	МОСКВА
XXIII	2018.6.20-21	Эрдэнэт
XXIV	2019.07.15-19	ЭРХҮҮ /ИРКУТСК/
XXV	2021.12.14	Улаанбаатар (Цахим)

**Хамтран гаргасан эмхэтгэлүүд**

Хамтарсан комиссын үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл бол Протокол бичгийн 2 дугаар зүйлд дурдсанчлан “Архивын баримт бичгийг хэвлэн нийтлэх” ажил юм.<sup>3</sup>

1996 оноос хойш Монгол, Оросын архивчид хоёр улсын нам, улс төр, цэрэг, соёл, шинжлэх ухаан, эдийн засгийн харилцааны түүхэнд холбогдох архивын баримт бичгээс бүрдсэн 13 боть, 700 гаруй хэвлэлийн хуудас цуврал эмхэтгэлийг хамтран бэлтгэж хэвлүүлжээ. Эмхэтгэлүүдэд голдуу урьд өмнө хэвлэгдээгүй, судалгааны эргэлтэд ороогүй шинэ баримтуудыг хэвлэн нийтэлдэг онцлогтой.

<sup>3</sup> Монгол Улсын Үндэсний төв архив, Х-445, Д-4, ХН-4, хуудас-2

Эдгээр эмхэтгэлд орсон архивын баримт бичгүүд нь ХХ зуунд Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааны түүхийг судлах судлахад архивын гол тулгуур эх сурвалж болж байна.

Д/д	Баримт бичгийн эмхэтгэлийн нэр (Наименование сборника)	Хэвлэгдсэн он (Год издания)
1	Коминтерн ба Монгол (Коминтерн и Монголия)	УБ. 1996 он. 502 хуудас (стр) 38,5 хх (п.л)
2	Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа (1921-1960). I боть (Монголо-Советские научные и культурные связи. Том 1. 1921-1960 гг.)	УБ. 2000 он. 681 хуудас (стр) 42,5 хх (п.л)
3	Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1920-1952) I боть 1920-1932 он (Монголия в документах ВКП /б/. 1920-1952 гг. Том 1. 1920-1932 гг.)	УБ., 2002 он. 559 хуудас (стр) 40 хх (п.л)
4	Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг (1920-1952) II боть 1933-1940 он. (Монголия в документах ВКП /б/. 1920-1952 гг. Том 2. 1933-1940 гг.)	УБ., 2005 он. 471 хуудас (стр). 40 хх (п.л)
5	Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946) I боть. 1911-1936 он. (Монголо-Российское военное сотрудничество. (1911-1946). Том 1. 1911-1936 гг)	УБ., 2007 он. 533 хуудас (стр) 45 хх. (п.л)
6	Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946). Часть I. (Орос-Монголын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). I боть)	Москва- Улан-Удэ., 2008 г. 349 стр. 44,0 (п.л)
7	Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946). Часть II. (Орос-Монголын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). II боть)	Москва- Улан-Удэ., 2008 г. 326 стр. 41,0 (п.л)
8	Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг (1920-1952) III боть 1941-1952 он. (Монголия в документах ВКП /б/. 1920-1952 гг. Том 3. 1941-1952 гг.)	УБ., 2009 он. 390 хуудас (стр) 32,5 хх (п.л)
9	Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946) II боть. 1936-1946 он. (Монголо-Российское военное сотрудничество. (1911-1946). Том 2. 1936-1946 гг)	УБ., 2011 он. 497 хуудас (стр) 50,5 хх (п.л)
10	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн түүхэнд холбогдох архивын баримт, эх сурвалж /1963-2013/ Архивные документы и источники, касающиеся и истории создания и развития КОО “предприятия Эрдэнэт” /1963-2013 гг/	УБ., 2013 он. 424 хуудас (стр) 35 хх (п.л)

11	Вооруженный конфликт в районе Халхин-Гол. Май-сентябрь 1939 г. Документы и материалы. (Халх гол орчим дахь зэвсэгт мөргөлдөөн. 1939 оны тав- есдүгээр сар)	Москва., 2014 г. 518 стр. 43,42 п.л
12	Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухааны харилцаа. Баримт бичгийн эмхэтгэл. Дэд боть. 1961-1975 он. (Монголо-Советские научные и культурные связи. Том 2. 1961-1975 гг.)	УБ., 2014 он. 610 хуудас (стр) 51,7 хх (п.л)
13	Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухааны харилцаа. Баримт бичгийн эмхэтгэл. Гутгаар боть. 1976-1990 он. (Монголо-Советские научные и культурные связи. Том 3. 1976-1990 гг.)	УБ., 2017 он. 633 хуудас (стр)

### **Хамтран зохион байгуулсан архивын баримтын үзэсгэлэнгүүд**

Хамтарсан комиссын үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл нь “...харилцан тохирсон сэдвийн дагуу үзэсгэлэн...” байгуулах юм.

1993 оноос хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны тэмдэглэлт ой, түүхэн үйл явдалд зориулан тодорхой сэдэв, асуудал, он цагийн хүрээнд архивын баримт бичиг, гэрэл зургийн хэд хэдэн үзэсгэлэнг Улаанбаатар, Москва, Санкт-Петербург, Эрхүү зэрэг хотноо амжилттай зохион байгуулж, олон нийтийн хүртээл болгосон юм. Үзэсгэлэн зохион байгуулах асуудалд Хамтарсан комисс онцгой ач холбогдол өгдөг бөгөөд ээлжит хуралдаанаар дараагийн удаад гаргах үзэсгэлэнгийн сэдвийг хэлэлцэж тохирдог, бэлтгэл ажил болох-архивуудаас баримт, гэрэл зураг сонгохыг 2 тал тус тусдаа гүйцэтгэж, үзэсгэлэнд тавигдах баримт, гэрэл зургуудыг зохион байгуулах талд хуулбараар тайлбарын хамт явуулдаг байна. Тухайлбал, 2011 оны Улаанбаатарт гаргасан “Монгол-Оросын харилцаа-XX зуун” үзэсгэлэнд зориулж ОХУ-ын Гадаад бодлогын түүхийн төв архив, Нийгэм-улс төрийн түүхийн төв архив, Эдийн засгийн төв архив, Цэргийн түүхийн төв архив зэрэг 8 архиваас 200 орчим баримт бичиг, 100 гаруй гэрэл зургийг манайд ирүүлсэн юм. Мөн хамгийн сүүлд 2019 онд Хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр замын 70 жилийн ойд зориулсан «Найрамдлын зам» сэдэвт Монгол-Оросын хамтарсан түүхэн-баримт бичгийн үзэсгэлэнг Эрхүү хотод, 2021 оны 09 сард “Монгол-Орос сайн хөрш, хамтын ажиллагааны зуун жил” сэдэвт үзэсгэлэнг Владивосток хотод тус тус амжилттай зохион байгуулсан.

Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахалын үед ч бид үзэсгэлэнд тавигдах баримтыг солилцож, цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

Үзэсгэлэнгийн нээлтийг зохион байгуулагч тал голдуу Хамтарсан комиссын ээлжит хуралдааны үеэр ёслол төгөлдөр хийдэг уламжлал тогтсон байна.

Удаа дараагийн гаргасан хамтарсан үзэсгэлэнгийн ач холбогдол нь Оросын Холбооны улстай тогтоосон улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, цэргийн

харилцаа зэрэг бүх талын хамтын ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэх, батлан хамгаалах, нийгэм, эдийн засаг, соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чухал хүчин зүйл болж ирснийг олон нийтэд ил тод томруунаар архивын бодит баримт бичиг, гэрэл зургаар харуулах явдалд оршдог.

### **Монголын судлаачид ОХУ-ын төв архивуудад ажилласан нь**

Архивын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хамтарсан комиссын нэг зохион байгуулж байгаа ажил бол Монголын архивын судлаачдыг ОХУ-ын төв архивуудад ажиллахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Хамтарсан комиссын шугамаар манай архивын судлаач, түүхч эрдэмтдийн хэсэг 1993 оноос Оросын нийгэм-улс төрийн түүхийн төв архив (РГАСПИ), Гадаад бодлогын төв архив (АВП РФ), Цэргийн түүхийн төв архив (РГВИА), Эдийн засгийн төв архив (РГАЭ), Оросын Холбооны Улсын архив (ГАРФ), Кино, гэрэл зургийн баримтын төв архив (РГАКФД) зэрэг архивуудад судалгаа хийж, Монгол Улсын болон хоёр улсын харилцааны ХХ зууны түүхэнд холбогдох 10000 гаруй хуудас баримтыг хөнгөлөлттэй нөхцөлөөр хуулбарлан авсан.

Оросын тал монголын судлаачдад өөрийн орны архивд ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн төдийгүй, мөн зарим ховор архивын баримтын хуулбарыг Комиссын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан архивын баримт бичиг солилцоо, баримтын үзэсгэлэн зэрэг арга хэмжээний үеэр манайд үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн байдаг.

Эдүгээ дээрх баримт бичгүүд нь Монгол Улсын Үндэсний төв архив, Гадаад харилцааны болон Батлан хамгаалахын төв архивуудад тусгай хөмрөгт тусдаа бүртгэлтэй хадгалагдаж байна.

Энэ баримтуудын нууцын зэрэглэлээс ил болсон урьд өмнө түүх, эрдэм шинжилгээний эргэлтэд орж байгаагүй учраас ХХ зууны Монголын түүхэн үнэнийг нээн харуулах, түүх судлалд чухал ач холбогдолтой эх сурвалж юм. Иймээс цаашид эдгээр баримтын иж бүрэн болон сэдэвчилсэн жагсаалтыг гаргах, эрдэм шинжилгээ, судалгаанд өргөн ашиглуулдаг болох шаардлагатай байна.

### **Архив, албан хэрэг хөтлөлтийн хамтарсан арга хэмжээ**

Хамтарсан комиссын шугамаар анх 1994 онд Архивын ерөнхий газрын мэргэжилтнүүд Оросын Холбооны Улсын төв архив (ГАРФ), Оросын шинжлэх ухаан, техникийн төв архив (РГАНТД) үйл ажиллагаатай танилцах туршлагыг судалж байжээ. Мөн 1994 онд Улаан-Үдэд архивын “Архивын эрдэм шинжилгээний аппаратыг боловсронгуй, баримтын нөхөн бүрдүүлэлт”, 2011 онд Улаанбаатарт Свердловск мужийн архивын төлөөлөгчидтэй архив, албан хэрэг

хөтлөлтийн онол, арга зүйн асуудлаар хамтарсан дугуй ширээний ярилцлага зохион байгуулж байжээ.

1994 онд Архивын ерөнхий газар, Буриад улсын архивын хэргийн хорооны хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулсан бөгөөд 2015 онд Архивын ерөнхий газар, Үндэсний төв архив, Нийслэлийн архивын газрын мэргэжилтэн, архивын хэсэг ажилтнууд Улаан-Үд хотод очиж Буриад улсын архивын үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцсон нь мэргэжлийн чиглэлийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд тодорхой хувь нэмэр болсон.

Хамтарсан комиссын Эрдэнэт хотод болсон ээлжит IX хуралдаанаас монголын архивчдад зориулсан сургалтыг ОХУ-ын Архив зүй, баримт бичиг судлалын эрдэм шинжилгээний хүрээлэнг (ВНИИДАД) түшиглэн тогтмол явуулж байх чухал шийдвэр гаргасан юм.

Энэ дагуу 2001 оны 2 дугаар сараас мэргэжил дээшлүүлэх сургалт эхэлсэн бөгөөд 2001-2012 онд Монголын төрийн болон байгууллагын архив, бичиг хэргийн ажилтан нийт 100 гаруй хүн ОХУ-д богино хугацааны сургалтад хамрагдан мэргэжил дээшлүүлсэн байна.

### Дүгнэлт

Өнгөрсөн хугацаанд хамтарсан комиссын хүрээнд Монгол-Оросын төрийн архивуудад хадгалагдаж байгаа урд өмнө судалгааны эргэлтэд ороогүй хаалттай байсан түүхийн чухал баримт бичгийг судлах, сурвалжлах, хуулбараар солилцох, хамтарсан эмхэтгэл ном хийх, архивын ажлын туршлага солилцох, мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, Монгол-Оросын харилцааны түүхийн чухал сэдвээр архивын баримтын үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчлан таниулах зэрэг тодорхой чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж, үр дүнтэй ажилласан.

Цаашид хоёр улсын архивын хамтын ажиллагаа ОХУ-ын архивын байгууллагуудын сургалтын баазыг түшиглэн, Монголын архивын ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах, харилцан мэргэжилтэн солилцох ажлыг эрчимжүүлэх, бүс, орон нутгийн архивуудын хамтын үйл ажиллагааг дэмжих шаардлагатай.

Мөн Архивын баримтыг сурталчлах хэвлэн нийтлэх талаар тодорхой сэдвийн хүрээнд хамтарсан баримт бичгийн эмхэтгэл бэлтгэх, үзэсгэлэн зохион байгуулах ажлуудыг үргэлжлүүлэхээс гадна Монголын түүх соёлд холбогдох баримтыг судалж илрүүлэх, хуулбарлан авах, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах, харилцан судлаач солилцож хоёр улсын архивуудад ажиллах нь үр дүнтэй байх болно.